**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

**НИЙЛҮҮЛЭГЧ**

ИЛДЭНГҮН ХОШУУ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.ТУНГАЛАГ

# ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 18

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Илдэнгүн Хошуу ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь ариутгал халдваргүйтлийн бодисыг нийлүүлэх гэрээг (цаашид “бараа” гэх) 9,838,400 (есөн сая найман зуун гучин найман мянга дөрвөн зуу) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Клорсепт | 26 | Ирланд / Medentech | фл | 208 | 47,300 | 9,838,400 |
| **Нийт дүн** | | | | | | **9,838,400** |

1 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 9,838,400 (есөн сая найман зуун гучин найман мянга дөрвөн зуу) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2 Нийлүүлэгч нь 12 нэр төрлийн барааг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Клорсепт | 26 | = | 9,838,400 |
| | **Нийт дүн** | | = | **9,838,400** |

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

| | |
|---|---|
| Н 23 | ГЕН-ийн 23-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 24)** | |
| Н 24 | ГЕН-ийн 24-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)** | |
| Н 25 | ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)** | |
| Н 26 | ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)** | |
| Н 27.1 | Монгол хэл |
| **Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)** | |
| Н 28.1 | Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө |
| **Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)** | |
| 29.1 | Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2 |
| **Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)** | |
| 30 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**…АГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

…дийн яамны Эм, эмнэлгийн
…үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
……………………Г.Цэцэнсанаа

…дийн яамны Хөрөнгө оруулалтын
дарга
……………………Т.Бямбасүрэн

…дийн яамны Эм, эмнэлгийн
…үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
……………………Т.Мөнхтуул

…дийн яамны Хөрөнгө оруулалтын
мэргэжилтэн
……………………Г.Бат-Эрдэнэ

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Идэнгүн Хошуу ХХК-ий
Менежер
……………………Д.Эрдэмбилэг

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛААНБААТАР ХОТ ИДЭНГҮН ХОШУУ ХХК 2565242 ТТ59074

*Хаяг: БЗД, 14 хороо, Намян Жу гудамж*
*Утас: 95950538, 99095551*

*Харилцах банкны нэр:*

*ХАС БАНК*
*Дансны дугаар:*

*5000005075*